

Mongolian language for foreigners – Week 11
Lecture №11

Сэдэв: Монголчуудын үндэсний хувцас
Topic: Mongolian national clothing

Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх
listening, speaking, reading, writing

Mongolian National University Arts And Culture
Professor, Basbish.S

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing previous learning
2. Монголчуудын үндэсний хувцас– Mongolian national clothing
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework



Монголын радио. (2018, August 3). Монгол үндэсний хувцас [Photograph]. www.mnb.mn. <https://www.mnb.mn/i/148017>

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест – Test

1. Монгол гэрийг дүрсэлсэн хадны зураг хэдий үед холбогдох вэ?

- A. Хүй нэгдлийн үе Б. Хүрэл зэвсгийн үе В. Төмөр зэвсгийн үе Г. Дундад зууны үе

2. Гэрийг эртнээс монгол гэр,..... гэж ялгаж үздэг байв.

- A. Орчин үеийн гэр Б. Түрэг гэр В. Орос гэр Г. Хятад гэр

3. Монголчууд жилийн дөрвөн улиралд малынхаадаган нүүдэллэдэг.

- А. Бэлчээрийг Б. Хотыг В. Хашааг Г. Нутгийг

4. Монгол гэр ,бүрээс, оосор бүч, бүслүүрээс бүрддэг.

- A. Тулгуур мод Б. Суурь мод В. Хүрээ мод Г. Яс мод

5. Монгол гэрийн тооно, унь, хана, багана, хаалга орно.

- A. Тулгуур модонд Б. Суурь модонд В. Хүрээ модонд Г. Яс модонд

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

6. Монголчууд гэрийнхээ үүдийг нар ургахзүг рүү харуулан барьдаг.

- A. Баруун хойд Б. Зүүн хойд В. Баруун өмнө Г. Зүүн өмнө

7. Гэрийн их бага ньтооноос хамаардаг бөгөөд 4,5,6,8,9,10,12.....гэр гэж ангилан үзнэ.

- A. Унины, уньтай Б. Хананы, ханатай В. Тоононы тоонотой Г. Хаалганы, хаалгатай

8. Хамгийн түгээмэл гэр бол.....ханатай гэр юм.

- A. 3,4 Б. 5,6 В. 7,8 Г. 9,10

9. Айлд орохдоо босгонд тээглэж бүдэрвэл тийм хэмжээний.....орох нь гэж бэлгэшээдэг.

- А. Олз Б. Гарз В. олдвор Г. Ашиг

10. Гэрийнхамгийн хүндтэй хэсэг бөгөөд энэ хэсэгт бурхан шүтээнээ залж, гэрийн эзэн сууна. Мөн хүндтэй зочдыг энэ хэсэгт урьж суулгадаг

- A. баруун Б. зүүн В. Хоймор Г. хана

Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.

1. Монгол үндэсний хувцас ямар онцлогтой вэ?
2. Монгол үндэсний хувцаснаас нэрлэнэ үү!
3. Монголчууд дээл хувцсаа юугаар хийдэг вэ?

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning*

1. Амьдралын хэв маяг - lifestyle
2. Буян хишиг – good fortune
3. Бэлгэдэл - symbol
4. Бэхлэн батжуулах – yo strengthen
5. Ван -king
6. Гол төлөөлөл – main representation
7. Гүн - king
8. Дээл- Mongolian Traditional garment
9. Зээгт наамал - applique
10. Мал аж ахуй эрхлэх – to breed traditional kinds of livestock
11. Манж маягийн тав гэзэг – Manchu style pigtail (queue)
12. Мандах- to flourish, prosper
13. Нударга – cuff (of Mongolian traditional garment)
14. Оноо - slit
15. Отго, жинс – peacock feather and button of rank (on a hat)
16. Угалз – spiral type of pattern

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning*

- | | |
|--|------------------------------------|
| 18. Уламжлалт сэтгэлгээ – traditional thinking | 27. Хатгамлах – to embroider |
| 19. Ууж – long sleeveless garment worn by women over the dress | 28. Хоргой торго - brocade |
| 20. Үндэстний онцлог – nationality characteristics | 29. Цаг уур - climate |
| 21. Солгой тал – left side | 30. Цэмбэ – woolen cloth |
| 22. Тайлга ёслолын хувцас – ceremonial dress | 31. Цээрлэх – to forbid |
| 23. Товч хадах – to sew a button | 32. Шингээх – to include |
| 24. Тодорхойлох – to determine | 33. Эвлүүлэх – to assemble |
| 25. Тэгш намбатай - dignified | 34. Энэрэнгүй үзэл - humanism |
| 26. Хантааз - jacket | 35. Эрхэмлэн хүндэтгэх- to respect |

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

Монголчуудын үндэсний хувцас

Монголчуудын дээл хувцас бол монгол 1) _____ онцлогийг тодорхойлдог хамгийн чухал зүйлсийн нэг. Монгол хувцас нь Монгол орны цаг уур, хүн ардын эрхэлж буй мал аж ахуй, амьдралын хэв маяг, уламжлалт сэтгэлгээ, соёл, зан заншилтай нягт холбоотой.




Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

Монгол үндэсний хувцасны 2) _____
нь малгай, дээл, бүс, хантааз, гутал. Эдгээр нь өөр
өөрийн гэсэн бэлгэдлийн утга агуулгатай. Үүнд: **Мандах
төрийн малгай** хэмээхийн учир нь хүний биеийг шударга,
ёстой төртэй, 3) _____ явахыг бэлгэдсэн
байна. Ийм учраас Монголчууд малгайг ихэд хүндэтгэн
эрхэмлэж, газар тавих, дээгүүр нь алхах, гишгихийг
цээрлэдэг.



Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

Тэгш төрийн дээл хэмээхийн учир нь хүний биеийг төв шулуун, тэгш намбатай байхыг ерөөж ийнхүү нэрлэжээ. 4) _____ **төрийн бүс** гэдэг нь задгай тасархайг бэхлэн батжуулах, сарнисныг эвлүүлэхийн утгатай. **Хан төрийн хантааз** гэдэг нь төр улсын иргэн мөн гэдгийн баталгаа бөгөөд аливаа хүндэтгэл, ёслолд заавал өмсөх өмсгөл.



Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words**

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

5) _____ төрийн гутал нь хүний биеийн тулгуур болсон хөлийн өмсгөл тул тулж түших, бат суурьтай явахыг бэлгэдсэн. Гутлын ээтэн хошуу, толигор ул нь газар шороог гэмтээхгүй, ургамал, амьтны аминд хүрэхгүй гэсэн энэрэнгүй үзлийг шингээсэн.



Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words**

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

Монгол үндэсний хувцас баруун, зүүн, төв гэж хуваагддаг бөгөөд б) _____ үндэстэн, ястны хувцаснаас бүрдэнэ. Монголын олон ястны өвөрмөц төрхийг илэрхийлсэн хувцас хэрэглэл нь содон төрх, ур хийцээрээ тухайн угсаатан ястны соёл, зан заншлыг илэрхийлсэн, бэлгэдлийг шингээсэн байдгаараа бусдаас ялгарна.



(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 85)

Munkhbat. (2016, November 11). Монгол үндэстний хувцас [Photograph]. chuham.mn.
<http://chuham.mn/index.php?newsid=6987>

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

Монгол үндэстэн, ястнуудын хувцас



Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words**

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

Монголчууд хүний 7) _____ хувцандаа байдаг бөгөөд эрэгтэй хүнийх бүсэнд, эмэгтэй хүнийх чимэг зүүлтэнд нь тогтдог гэж үздэг. Монгол хувцас нь малгай, дээл, ууж, хүрэм, хантааз, дотуур хувцас, гутал зэргээс бүрдэнэ. Дээл хувцасны гол материал нь торго.



Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг,
Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг*

Монгол хувцас ястан ястны онцлогийг хадгалах боловч монгол туургатныг илтгэх нэг хэв маягтай, ижил төстэй загвартай байдаг. Ястан ястны эрэгтэйчүүдийн хувцас ерөнхийдөө адил боловч өөр хоорондоо бага зэрэг ялгаатай. Монгол эрчүүдийн нийтлэг хэрэглэдэг байсан нэгэн зүйл бол хэт, хутга юм. Харин эмэгтэйчүүдийн хувцас, түүний дотор 8) _____ хүний хувцас хэрэглэл нилээд өвөрмөц бөгөөд тэрхүү ялгаа нь дээлийн энгэр, нударга, уужны мөр, зах, үсний хэв маяг, чимэглэл, гутал зэрэг дээр тод харагддаг байна.

Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг,
Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг*

Эрт үеийн монгол хувцас: Эртний монгол хувцас гэдэг нь Монгол нутагт анхны төр улсыг байгуулсан 9) _____ нарын хувцаснаас эхлэлтэй. Хүннү нар баруун зүүн тийш зөрдөг энгэртэй дээл, ээтэн хоншоортой гутал, бүс хэрэглэж байжээ. Сяньбичууд Хүннү нартай ижил дээл өмсөж, Жужанууд өмнөхтэй адил энгэртэй, нарийн ханцуйтай дээл, урт түрийтэй гутал өмсдөг байжээ.

Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг,
Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг***

Харин Түрэг угсаатны дээл нь урдуураа задгай, буруу зөрдөг энгэртэй байсны дээр гутал, малгай зэрэг нь өөр байжээ. 10) _____ хувцас нь дундад эртний монгол хувцасны үүсгэл болж түүнд тулгуурласан монгол дээл хувцасны хэв маяг бүрэлдэн тогтсон гэж судлаачид үздэг.

Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг,
Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг*

Дундад эртний монгол хувцас: XIII зууны үед Монголчуудын дээл зөв ташуу энгэртэй, гутал нь ээтэн хоншоортой, толгойн өмсгөл нь алчуур, юүдэн болон хив малгай байжээ. Дээлнийхээ солгой талд оноо хийж, баруун талдаа 3, зүүн гар талдаа 1 товч хаддаг байв. Монголын их хаад Мөнх, Хубилай нар тайлга ёслолын хувцасны 11) _____ тогтоосон бөгөөд монгол дээлний хэв маягийг хэвээр хадгалж чимэг зүүлтийг нэмжээ.

Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг,
Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг***

Хубилай хааны хатан Чинбай хувцасны загвар хийцийг зохиож урладаг ухаалаг нэгэн байсан бөгөөд монгол хувцсанд түүний нөлөө их байсан. Монголчууд дээл хувцсаа цэмбэ, арьсаар голдуу хийдэг байжээ. Харин XIII зууны үеэс торгомсог бөс, алтан саагаар хатгамалсан хоргой торгоор хийдэг болж, эрдэнийн чулуун шигтгээ бүхий хээ угалз, зээгт наамлаар чимэглэдэг байжээ.

Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг,
Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг*

Дундад зууны үеийн монгол хувцас: Манж чин улс ХҮИИ зууны үеэс Хятад, Монгол зэрэг орныг эрхшээлдээ оруулснаар 12) _____ хувцасны зарим хэв маяг дэлгэрсэн. 1759 онд хувцасны хууль гаргаж монгол ван, гүнгүүдийн цол хэргэм, зэрэг дэвийн хувцасны маяг, хэрэглэх зүйлийг тусгайлан заасан байна.

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words**

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

Монгол эрчүүд манж маягийн тав гэзэг тавьж, дөрвөлжин энгэртэй дээл өмсөх болсон ба дээлний ханцуй нь нударгатай болжээ. Манжийн үед шинээр бий болсон хувцас бол лам дээл хувцас бөгөөд эртний монгол дээлний энгэрийг өвлөн авсан байна.



Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

Орчин үеийн монгол хувцас: 13) _____ оны ардын хувьсгалын дараа ноёд түшмэдийн аливаа баяр ёслолд өмсдөг урт дээл хүрэм, отго жинс зэргийг болиулжээ. Нүүдлийн соёлоос суурин соёл руу шилжсэнээр ард олны хувцас хөнгөрч, богино хүрэм, энгийн хийцтэй, нударгагүй ханцуйтай шулуун дээл өмсөх болсон.



Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words**

Нөхөх үгс - Choose from following words: 1921, үндэстний, Киданчуудын, буян хишиг, Бүтэх, гол төлөөлөл, манж, эхнэр, Түших, Хүннү, мандан бадарч, 20 орчим, хуулийг

Дээлний зах, эмжээр, суга, ташаа нь нарийсч, эсгүүр хийц нь өөрчлөгдсөн бөгөөд эмэгтэйчүүдийн дээлний энгэр захыг хоргойгоор эмждэг болжээ. Өөрөөр хэлбэл, монгол үндэсний хувцас хамгийн энгийн бөгөөд сонгодог загварт шилжсэн юм.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 86)



Дасгал 3. Эхийг сонсоод ойлгоорой.
Exercise 3. Listen and understand

Шинэ хувцас мялаах ёс

Бие сэтгэлд яв цав зохицсон дээл хувцас нь хүний цог хийморийг сэргээдэг. Харин хүүхэд багачуудын хувьд шинэ дээл хувцас өмсөх нь нэгэн ёсны баяр юм. Монгол хүн шинэ дээл мялаах, ерөөх нарийн ёс горимтой. Шинэ дээл өмссөн хүүхэд орж ирэхээр:

Урд хормой дээр нь

Унага даага гишгэл

Хойд хормой дээр чинь

Хонь хурга харайлд

Дотоод хормой дээр чинь

Тос өөх наалдаг

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

Дасгал 3. Эхийг сонсоод ойлгоорой. Exercise 3. Listen and understand

Эд нь хэврэг

Эзэн нь мөнх

Энэнээс сайхныг

Эдэлж яваарай гэж ерөөгөөд дотоод хормойд нь
тос өөх түрхэж, чихэр жимсээр мялаадаг.

Сүүлийн үед нийгэм цаг үе, хүмүүсийн амьдралын
хэв маяг, хэрэглээ шаардлага өөрчлөгдсөнтэй
уялдан дээлний хэв загвар шинэчлэгдэж байна.

(Баттулга, Ч, 2020, хууд. 74)



Монголын радио. (2019, February 4). Тэгш төрийн дээл [Photograph].
www.mnb.mn. <https://www.mnb.mn/i/164471>

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

Дасгал 4. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 4. Discuss about following questions and review your understanding

1. Монголчуудын дээл хувцас ямар онцлогтой вэ?
2. Монголчуудын хувцасны гол төлөөлөл нь юу юу вэ?
3. Монголчууд малгайг яагаад эрхэмлэн дээдэлдэг вэ?
4. Монгол дээл юуг бэлгэддэг вэ?
5. Монгол бүс юуг бэлгэддэг вэ?
6. Хантааз юуг бэлгэддэг вэ?
7. Монгол гутал юуг бэлгэддэг вэ? Монгол гутал яагаад ээтэн хоншоортой байдаг вэ?

Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

Дасгал 4. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 4. Discuss about following questions and review your understanding

8. Монголчууд хүний буян хишиг юунд байдаг гэж үздэг вэ?
9. Монгол угсаатан ястнуудын хувцас яагаад ялгаатай байдаг вэ? Юу юугаараа ялгардаг вэ?
10. Монголчуудын эртний хувцас хэзээнээс эхлэлтэй вэ? Эрт үед Монголчууд юу өмсдөг байсан бэ?
11. Дундад эртний үед Монголчууд дээл хувцасаа ямар материалаар хийдэг байсан бэ? Энэ үед хувцсанд ямар өөрчлөлт гарсан бэ?
12. Дундад зууны үеийн Монгол хувцсанд ямар өөрчлөлт гарсан бэ?
13. Орчин үеийн монгол хувцас хэзээ бий болсон бэ?

Монголчуудын үндэсний хувцас
Mongolian national clothing

Дасгал 5. Онъсогыг уншаад таацгаая.

Exercise 5. Read the riddle and try to guess the answer.

Чи үүгээр яв
Би түүгээр явъя
Билүүтийн гол дээр уулзъя.

Тэр юу вэ?

Өдөр бүр залгана
Шөнө бүр салгана.

Тэр юу вэ?

Их гэрийн дотор бага гэр
Бага гэрийн дотор балчир хүүхэд
Тэр юу вэ?

Гартай байж хөлгүй
Хүзүүтэй байж толгойгүй.
Тэр юу вэ?

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

Гэрийн даалгавар 1 Homework 1

Мэдлэг шалгах тест – Test

- 1. Монголчуудын дээл хувцас бол монгол онцлогийг тодорхойлдог хамгийн чухал зүйлсийн нэг юм.**
A. Хэлний Б. Үндэстний В. Улсын Г. Орны
- 2. Монгол үндэсний гол төлөөлөл нь малгай, дээл, бүс, хантааз, гутал юм.**
A. Эдлэлийн Б. Чимэг зүүлтний В. Хоолны Г. Хувцасны
- 3. Монголчууд ихэд хүндэтгэн эрхэмлэж, газар тавих, дээгүүр нь алхах, гишгэхийг цээрлэдэг.**
A. Малгайг Б. Гутлыг В. Өмдийг Г. Ороолтыг
- 4. Тэгш төрийн хэмээхийн учир нь хүнийг төв шулуун, тэгш намбатай байхыг ерөөж ийнхүү нэрлэжээ.**
A. Цамц Б. Хүрэм В. Дээл Г. Майк
- 5. Бүтэх төрийн нь задгай, тасархайг бэхлэн батжуулах, бутарсныг эвлүүлэхийн утгатай.**
A. Ороолт Б. Зүүлт В. Бүс Г. Тэлээ

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

Гэрийн даалгавар 1 Homework 1

6. Хан төрийнгэдэг нь төр улсын иргэн гэдгийн баталгаа бөгөөд аливаа хүндэтгэл, ёслолд заавал өмсөх өмсгөл юм.

А. Дээл

Б. Хантааз

В. Цамц

Г. Хүрэм

7. Мандах төрийнхэмээхийн учир нь хүнийг шударга, ёстой төртэй, мандан бадарч явахыг бэлгэдсэн байна.

А. Алчуур

Б. Ороолт

В. Малгай

Г. Зүүлт

8. Түших төрийннь хүний биеийн тулгуур болсон хөлийн өмсгөл учраас тулж түших, бат суурьтай явахыг бэлгэдсэн.

А. Малгай

Б. Гутал

В. Өмд

Г. Ороолт

9. Монголчуудын хувцас нь монгол нутагт анхны төрт улсыг байгуулсаннарын хувцаснаас эхлэлтэй.

А. Сяньби

Б. Хүннү

В. Жужан

Г. Түрэг

10.онд хувцасны хууль гаргаж, монгол ван, гүнгүүдийн цол хэргэм, зэрэг дэвийн хувцасны маяг, хэрэглэх зүйлийг тусгайлан заасан байна.

А. 1459


Б. 1559

В. 1659

Г. 1759

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

Гэрийн даалгавар 2 Homework 2



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- *Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.
Memorize vocabulary in the given topic*
- *Өөрийн орны үндэсний хувцасны талаар бичээрэй.
Write about the national clothing in your country*

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Мөнхцэцэг, Г., Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Баттулга, Ч (2020). Монгол орон судлал. Улаанбаатар: Удам соёл ХХК.

Монголын радио. (2018, August 3). Монгол үндэсний хувцас [Photograph].www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/148017>

Marcin, K. (2010, July 16). Traditional Mongolian costumes [Photograph]. mn.wikipedia.org.

[https://mn.wikipedia.org/wiki/%D0%94%D1%8D%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Przed_rozpoznaniem_lokalnego_festiwalu_Naadam_\(06\).jpg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%94%D1%8D%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Przed_rozpoznaniem_lokalnego_festiwalu_Naadam_(06).jpg)

Монголын радио. (2019, February 4). Мандах төрийн малгай [Photograph]. www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/164470>

Монголын радио. (2019, February 4). Тэгш төрийн дээл [Photograph]. www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/164471>

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Byambakhuu, D. (2011, January 19). Тулах төрийн гутал. tsagaansar.blogspot.com.

http://tsagaansar.blogspot.com/2011/01/blog-post_6848.html

Munkhbat. (2016, November 11). Монгол үндэстний хувцас [Photograph]. chuham.mn.

<http://chuham.mn/index.php?newsid=6987>

Munkhbat. (2016, November 11). Монгол үндэстний хувцас [Photograph]. chuham.mn.

<http://chuham.mn/index.php?newsid=6987>

Халх үндэстний хувцас [Photograph]. (2013, March 25). news.mn.

<https://news.mn/r/138184/>

Монголын радио. (2021, December 8). Лам дээл [Photograph]. www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/251440>

Үндэсний хувцас [Photograph]. (2022, July 9). www.24tsag.mn.

<https://www.24tsag.mn/a/205664>

Болор, Ж. (2022, January 26). Халх эхнэр дээл [Photograph]. montsame.mn.


<https://montsame.mn/mn/read/288063>

Монголчуудын үндэсний хувцас Mongolian national clothing

Анхаарал хандуулсанд
баярлалаа.



https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>